

# “ХӨВСГӨЛ” ХК

2024 оны 03 сарын 19-ний өдөр

№ 24/02

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурал зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.5, 59.10, 59.11 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг **2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 15:00 цагт цахим хэлбэрээр хуралдуулсугай.**
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, “Ард Секюритиз ҮЦК” ХХК-ийн цахим хуудас, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, холбоотой бусад баримт бичгийг бэлэн болгож 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.

8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:  
Хурал зохион байгуулах комиссын дарга:  
ТУЗ-ийн дарга Г.Уянга  
Хурал байгуулах комиссын гишүүд:  
Гүйцэтгэх захирал Г.Сэлэнгэ  
Нягтлан бодогч Б.Оюунсүвд
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:  
Барристер Кастос Хуулийн Фирмийн өмгөөлөгч П.Наранхүү  
миссын гишүүдээр:  
Барристер Кастос Хуулийн Фирмийн Хуулийн зөвлөх Р.Тамжид  
Барристер Кастос Хуулийн Фирмийн Хуулийн зөвлөх Г.Энхжин
10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Г.Сэлэнгэ-д даалгасугай.

ДАРГА  Г.УЯНГА